



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/21

Арвайхээр

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд
зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.б, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улаанбаатар хотоос Өвөрхангай аймгийн иргэдийг татан авах ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ноос 01 дүгээр сарын 27-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа М.Дэлгэрсайхан)-т тус тус даалгасугай.

2. Халдвартай бүсээс ирсэн иргэдийг гэрийн хязгаарлалтад 14 хоног байх хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, хяналт тавих ажлыг эрчимжүүлж, хамтран ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), сум, багийн Засаг дарга нар, СӨХ-ийн дарга, гудамж, хэсгийн ахлагч, Улаан загалмайн хорооны сайн дурын идэвхтэн гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн хүнсний болон бөөний худалдааны цэгүүдэд 18 хувиас дээших спиртийн агууламжтай архи, согтууруулах ундааг худалдаалахыг зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100051